



“ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН АЖИЛТАН” БЭЛТГЭХ СУРГАЛТЫН БҮРТГЭЛ ЯВАГДАЖ БАЙНА.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын офицер, ахлагч бүрэлдэхүүний сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуультай хамтран зохион байгуулдаг томилогдохын өмнөх сургалтыг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс түргэвчилсэн байдлаар зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Сургалтад хамрагдах хүсэлтэй иргэдийн бүртгэлийг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 07 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд бүртгэн Дундговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 201 тоот өрөөнд материал хүлээн авна.

Харилцах утас:80110162, 88609900

Элсэгчдэд тавигдах шаардлага:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллахыг сайн дураар хүссэн, 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн;
- Ял шийтгэл эдэлж байгаагүй;
- Ахлагчийн бүрэлдэхүүнд 30 хүртэлх настай байх;
- Бие бялдрын зөв хөгжилтэй, 170 см-ээс доошгүй өндөртэй;
- Шивээсгүй байх;
- Дээд боловсролтой. Зайлшгүй шаардлагаар ажлын сул орон тоонд судлагдсан, бусад тавигдах шаардлага хангасан бүрэн дунд боловсролтой иргэн байж болно.
- Байгууллагын хүний нөөцийн сул орон тооноос хамаарч, харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалтад зөвхөн эрэгтэй иргэдийг бүртгэнэ.
- Зөвхөн эмч, эмнэлгийн ажилтны сул орон тоонд эмэгтэй иргэдийг бүртгэнэ.

Бүрдүүлэх материал:

1. Ажилд орохыг хүссэн өргөдөл /өөрийн гараар бичсэн байх/;
2. Хувь хүний намтар /өөрийн эцэг эх, гэр бүлийн хүний эцэг эхийн намтар байна. Хувь хүний намтар бичих санамжийн дагуу бичсэн байх/;
3. Төрсний гэрчилгээний хуулбар, төрсний бүртгэлийн лавлагаа;
4. Иргэний үнэмлэхийн хуулбар;
5. Боловсролын үнэмлэх, диплом нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт;
6. Оршин суугаа баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;
7. Урьд ажиллаж байсан байгууллагын ажил байдлын тодорхойлолт /цэргийн байгууллагад ажиллаж байсан бол цолны лавлагаа/;
8. Төрийн албан хаагчийн анкет /2019 оны шинэ/;
9. Нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн дэвтэр;
10. Цээж зураг /4х6 хэмжээтэй 4 хувь, 3х4 хэмжээтэй 4 хувь/;
11. Цэргийн алба хаасан талаарх архивын лавлагаа, цэргийн үүрэгтний үнэмлэх
12. Өр төлбөртэй эсэх лавлагаа.